

“ОРХОН ХӨГЖИЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, UB MART худалдааны төвийн 519 тоотод “Орхон хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэв.

Энэхүү ээлжит хурлыг зохион байгуулах комиссын гишүүд хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хуралд компанийн нийт 117'437 ширхэг хувьцааны 101'210 ширхэг хувьцааг эзэмшигчид оролцсон бөгөөд хурлын ирц 86,1% -тайгаар хурал хүчин төгөлдөр эхэллээ.

Хурлыг тус компанийн ТУЗ-ийн дарга Д.Оюунжаргал нээв.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- Сайн байцгаана уу. “Орхон хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэн энэ өдрийн мэнд хүргэе. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна. Та бүхэнд хурлын дэг болон хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Бид энэ удаагийн хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах,
3. ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх,
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох “Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – г компанийн Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан танилцуулна.

Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан:

Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тус компани анх Орхонтуулын Сангийн аж ахуй нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1991 онд Хөгжил нэртэй 5000 бяруу бордох аж ахуй болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12-р сарын 02-ны өдрийн 30-р тогтоолоор “Цуу тайж” нэртэйгээр Хувьцаат компани болж, Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн, өмч хувьчлалын ягаан тасалбараар нийт хувьцааны 67 хувийг хувьчилж, 33 хувь нь Төрийн мэдэлд байсан.

МУ-ын Засгийн газрын 1997 оны 160-р тогтоол, ТӨХ-ны 1998 оны 126-р тогтоолоор “Цуу тайж” ХК-ийн төрийн мэдлийн 33 хувь буюу 38'754 ширхэг хувьцааг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, Төрийн өмчийн хорооны 1998 оны 4-р сарын 17-ний өдрийн 242 тоот тогтоолоор өмчлөх эрхийг 100 % хувьд шилжүүлсэн болно.

Компани нээлттэй зах зээлд 117,437 ширхэг хувьцаа гаргаснаас 100,621 ширхэг хувьцаа буюу 85,68 хувийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд худалдан авч төвлөрүүлээд байна.

“Орхон хөгжил” ХК нь хувьчлагдсанаас хойш 1991 оноос одоог хүртэл улаан буудайн тариалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

2010 оноос компанийн удирдлага шинэчлэгдсэн бөгөөд компанийн техникийн паркийг шинэчилэх зорилгоор нийт 9 нэр төрлийн 603 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Компанийн өнгөрсөн жилийн үйл ажиллагаа

Тариалалтын талаар:

Тайлант 2017 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн,

Тариалалтыг 5-р сарын 05-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд нийт 823 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 170 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

Тарианы соёололт, ургалтын явцад бороо чийг тааруу байсан тул ургац хураалт муу байсан болно. Мөн тариан 143 га талбайд мал орсноос тариаг хурааж чадаагүй болно.

Б.Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 850 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-рсарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-рсарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн машин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

В.Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаагаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн ачуулсан болно.

2017 онд 1 га-гаас 9,91 цн буюу нийт 815,59 тн ургац хураасан бөгөөд үүнээс 482,28 тн будаа борлуулж, 305 844,6 сая төгрөгний орлого олж, 262 000,3 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 43 844,3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- ТУЗ өмнөх оны ажлыг авч хэлэлцэж алдагдалтай ажилласан гэж дүгнэсэн. Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайханы танилцуулсан тайлангаас тодруулж асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид:

- Асуулт алга.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- Өөр асуух зүйл байна уу? Байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе. Бидний хэлэлцэх дараагийн асуудал бол “Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах, арилжааг сэргээлгэх байгаа. Энэ асуудлыг та бүхэнд ТУЗ – ийн гишүүн Н.Баттогтох танилцуулна.

ТУЗ – ийн гишүүн Н.Баттогтох:

- Хувьцаа эзэмшигч та бүхэн бизнес төлөвлөгөөтэй танилцан шийдвэрлэж өгөхийг хүсье. /Төслийг тараав/

ТУЗ – ийн гишүүн Гансүх:

- Компанийн цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй танилцлаа дэмжиж байна. Асуух зүйл алга

Хурлын дарга Д.Оюунжаргал:

Компанийн бизнес төлөвлөгөөтэй холбогдуулан санал хүсэлт байхгүй бол хурлын дараагийн асуудалд оръё. За дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх, энэ асуудлыг та бүхэнд Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан танилцуулна.

Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан:

- Орхон хөгжил ХК нь өмнөх онуудад алдагдалтай ажилласан, Төрийн банкны зээлтэй байгаа учир мөн энэ онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигч Н.Мөнхзул:

- дэмжиж байна. Асууж тодруулах зүйл алга байна.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- Санал хүсэлт байхгүй бол хурлын дараагийн асуудалд оръё. За тэгвэл дараагийн хэлэлцэх асуудал “Орхон хөгжил” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох тухай байгаа. Компанийн тухай хуулийн 75.4-т Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасан байдаг. Бид та бүхэний өмнө шинээр ТУЗ-д нэр дэвшиж байгаа ердийн зургаа, хараат бус гурван гишүүнд нэр дэвшигчдийн анкетыг тавьсан байгаа. Би та бүхэнд ТУЗ – д нэр дэвшигчдийн товч танилцуулгыг хүн тус бүрээр нь уншиж танилцуулъя.

1. ТУЗ – ийн ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа:

- ✓ **Дашзэвэгийн Оюунжаргал:** 1967 онд Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 3, нөхөр хүүхдийн хамт амьдардаг. 1985 – 1989 онд ОХУ – ын Эрхүү хотын УАААДС – ийг санхүү-эдийн засагч мэргэжлээр сурч төгссөн. Одоо “Орхон хөгжил” ХК – ийн ерөнхий захирлаар ажиллаж байгаа.
- ✓ **Намсрайн Мөнхзул:** 1961 онд Дархан-Уул аймагт төрсөн. Ам бүл 3, нөхөн хүүхдийн хамт амьдардаг. 2003 – 2006 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Эдийн засагч мэргэжлээр суралцаж төгссөн. Хувиараа бизнес эрхэлдэг.
- ✓ **Ганхуягийн Урантогос:** 1982 онд Төв аймгийн Зуунмод хотод төрсөн. Ам бүл 3, нөхөр хүүхдийн хамт амьдардаг. 1998 – 2002 онд Түшээ Хууль зүйн Дээд Сургуулийг эрх зүйч мэргэжлээр сурч төгссөн. Хуульч мэргэжлээрээ ажиллаж байгаа.
- ✓ **Жамбалын Очирсүх:** 1963 онд Дархан-Уул аймагт төрсөн. Ам бүл 3, эхнэр хүүхдийн хамт амьдардаг. 1996-1998 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Эдийн засагч мэргэжлээр суралцаж төгссөн. Хувиараа бизнес эрхэлдэг.

- ✓ **Бямбаагийн Соёл-Эрдэнэ:** 1992 онд Архангай аймгийн Хангай суманд төрсөн. Ам бүл 3, ээж дүү нарын хамт амьдардаг. 2010-2014 онд Хүмүүнлэгийн ухааны сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр төгссөн. Одоо СЭХҮТ ТӨҮГазарт Ахлах мэргэжилтэнээр ажиллаж байгаа.
 - ✓ **Даишэвэгийн Жаргалсайхан:** Улаанбаатар хотод 1963 онд төрсөн. Ам бүл 3, эхнэр охиныхоо хамт амьдардаг. 1981-1986 онд ХААДСургуулийг Агрономич мэргэжлээр сурч төгссөн. Одоо “Орхон Хөгжил” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.
2. ТУЗ – ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа:
- ✓ **Дувчиндоржийн Алтанчимэг:** 1974 онд Архангай аймгийн Цэцэрлэг хотод төрсөн. 1993 – 1997 онд Монгол улсын их сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр сурч төгссөн. Одоо “Одод” ХХК –д нягтлан бодогчоор ажиллаж байгаа.
 - ✓ **Санжаагийн Ариунбулган:** 1981 онд Дундговь аймагт төрсөн. Ам бүл 3, ээж аав охины хамт амьдардаг. 1998– 2002 онд Шихи-Хутуг ХЗДС-ийг Эрх зүйч мэргэжлээр сурч төгссөн. “Эрчим хүчний яам”–нд мэргэжилтэнээр ажилладаг.
 - ✓ **Чүлтэмийн Баянжаргал:** 1975 онд Улаанбаатар хотод төрсөн. хүүхдийн хамт амьдардаг. 1993-1997 онд Отгонтэнгэр дээд нягтланбодогч мэргэжлээр сурч төгссөн. Одоо “Одод” ХХК-д менежерээр ажилладаг.
- Эдгээр хүмүүс компанийн ТУЗ– ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшсэн байна. Та бүхний саналыг сонсьё. Нэр дэвшигчдийн талаар тодруулж асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид:

- Дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Энэ утгаараа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн их хариуцлагатай байх ёстой. Нэр дэвшиж байгаа хүмүүсийн талаар тодруулж асуух зүйл алга.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- ТУЗ – ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй иргэдэд татгалзах зүйлгүй гэж ойлгож болох уу?

Хувьцаа эзэмшигчид:

- Тийм, болно. Өөр тодруулж асуух зүйл алга.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцууллаа.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ч.Нарантуяа танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна.

“Орхон хөгжил” ХК-ийн 2018 оны 04 сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг 100%-ийн саналаар батлав.
3. Компанийн ТУЗ-ийн ногдол ашиг хувиарлахгүй талаар гаргасан тогтоолыг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.
4. Компанийн ТУЗ – ийн гишүүдийг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар сонголоо.

Хурлын дарга Д.Оюунжаргал хурлыг хаав.

Хурал: 12.05 цагт өндөрлөв.

Хурлын дарга: Д.Оюунжаргал

Тэмдэглэл хөтөлсөн: Г.Урантогос

